



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ховд АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 48,840,000.00 (дөчин найман сая найман зуун дөчин мянга) төгрөгийн балансын үнэ, 39,886,000.00 (гучин есөн сая найман зуун наян зургаан мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Говь-Алтай АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Ховд АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Батцагаан, "Говь-Алтай АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Алтанхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132061351
11-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны... дугаар сарын 18... өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

'ХОВД АЗЗА' ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ГОВЬ-АЛТАЙ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Зөөврийн асфальто бетон завод	2007	1	48,840,000.00	48,840,000.00	39,886,000.00	8,954,000.00
Нийт дүн					(дөчин найман сая найман зуун дөчин мянга)	(гучин есөн сая найман зуун наян зургаан мянга)	(найман сая есөн зуун тавин дөрвөн мянга)